



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/79/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: В.Наранцэцэг Утас: 89992463      Цахим хаяг: Naraa_2463@yahoo.com Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ /эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/86

БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ИЧИНХОРЛОО ТАНАА

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020435

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42.469.288.40</b>	<b>158.552.827.67</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	101.740.000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	101.740.000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	42.469.288.40	56.812.827.67
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	16.773.090.92	30.249.641.61
35130	Эм боох материал	16.773.090.92	30.249.641.61
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25.696.197.48	26.563.186.06
35410	Бичиг хэргийн материал	387.000.00	711.000.00
35420	Аж ахуйн материал	12.089.028.00	11.235.049.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1.093.000.00	1.093.000.00
35440	Түлш, шатах тослох материал	800.000.02	231.270.00
35450	Барилгын засварын материал	359.300.00	1.009.300.00
35460	Хүнсний материал	255.270.51	93.900.01
35470	Бусад хангамжийн материал	10.712.598.95	12.189.667.05
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1.243.808.397.81</b>	<b>1.275.722.306.19</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1.243.808.397.81	1.275.722.306.19
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1.237.144.397.81	1.269.058.306.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	1.237.995.610.00	1.286.145.610.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39.923.443.48	-73.935.217.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41.600.000.00	7.000.000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29.222.778.03	-2.527.777.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105.308.337.45	126.682.745.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95.341.503.85	-85.640.554.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35.235.474.40	34.073.578.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18.507.298.68	-22.740.077.55
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6.664.000.00	6.664.000.00
39301	Програм хангамж	450.000.00	450.000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450.000.00	-450.000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6.664.000.00	6.664.000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1.286.277.686.21</b>	<b>1.434.275.133.86</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3.820.448.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3.820.448.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3.820.448.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3.820.448.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1.282.457.238.21</b>	<b>1.434.275.133.86</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1.282.457.238.21	1.434.275.133.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	198.108.353.00	198.108.353.00
51101	Өмч: - төрийн	198.108.353.00	198.108.353.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	626.702.026.08	810.019.921.73
51210	Өмнөх үеийн үр дүн	626.702.026.08	658.202.026.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	151.817.895.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	457.646.859.13	426.146.859.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1.286.277.686.21</b>	<b>1.434.275.133.86</b>

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

СТ-2А

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>480.451.734.00</b>	<b>965.734.814.12</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>110.855.664.12</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	110.855.664.12
<b>120017</b>	<b>Үнэ төлбөргүй хүлээн авсан ҮХ</b>		<b>64.271.081.12</b>
<b>120018</b>	<b>Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал</b>		<b>45.584.583.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>480.451.734.00</b>	<b>854.879.150.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381.217.800.00	455.397.100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18.649.334.00	324.815.146.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15.602.034.00	74.880.646.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3.047.300.00	00.00
<b>131107</b>	<b>Нэмэлт орлого</b>		249.934.500
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	44.565.500.00	49.646.074.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44.565.500.00	49.646.074.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	36.019.100.00	25.020.830.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36.019.100.00	25.020.830.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>519.704.240.65</b>	<b>813.251.410.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>519.704.240.65</b>	<b>813.251.410.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	500.541.833.65	761.292.275.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	311.563.001.00	328.039.828.00
210101	Үндсэн цалин	219.380.672.00	188.907.172.00
210102	Нэмэгдэл	70.344.229.00	100.436.626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5.216.130.00
210104	Урамшуулал	21.838.100.00	33.479.900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41.774.999.00	42.022.881.00
210201	Тэтгэврийн даатгал	29.330.157.01	31.399.535.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.131.326.38	2.555.530.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.514.959.10	1.456.156.00
210204	Ажилгүйдлийн даатгал	602.185.69	646.913.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6.196.370.82	5.964.747.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34.925.083.00	47.908.874.00
210301	Гэрэл, цахилгаан	1.744.802.00	4.527.874.00
210302	Түлш, халаалт	32.986.081.00	42.581.000.00
210303	Цэвэр, бохир ус	194.200.00	800.000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23.385.312.98	84.642.105.41
210401	Бичиг хэрэг	1.495.400.00	2.564.850.00
210402	Тээвэр, шатахуун	11.835.611.98	16.727.264.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.569.000.00	3.703.201.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4.400.370.00	4.201.505.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2.654.900.00	31.781.415.49
210408	Бараа материал акталсны зардал	430.031.00	1.566.841.90
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	00.00	24.097.028.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	35.966.739.34	86.815.628.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29.814.897.34	70.935.794.82
210502	Хоол, хүнс	6.151.842.00	15.879.833.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	955.000.00	3.624.630.00

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	40.000.00
210604	Урсгал засвар	955.000.00	3.584.630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1.004.000.00</b>	<b>308.000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1.004.000.00	308.000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>494.800.00</b>	<b>102.007.945.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94.800.00	101.557.945.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400.000.00	450.000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50.472.898.33</b>	<b>65.922.383.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14.795.994.00	11.920.719.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35.676.904.33	54.001.664.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19.162.407.00</b>	<b>51.959.135.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15.602.034.00</b>	<b>41.187.846.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15.602.034.00	41.187.846.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>723.917.00</b>	<b>963.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	723.917.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2.836.456.00</b>	<b>10.770.326.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2.836.456.00	10.770.326.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-39.252.506.65</b>	<b>152.483.403.70</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>665.508.05</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	665.508.05
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-665.508.05</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-39.252.506.65</b>	<b>151.817.895.65</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>480.451.734.00</b>	<b>753.139.150.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>480.451.734.00</b>	<b>753.139.150.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381.217.800.00	455.397.100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18.649.334.00</b>	<b>223.075.146.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15.602.034.00	74.880.646.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3.047.300.00	00.00
<b>131107</b>	<b>Нэмэлт орлого</b>		<b>148.194.500.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>44.565.500.00</b>	<b>49.646.074.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44.565.500.00	49.646.074.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>36.019.100.00</b>	<b>25.020.830.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36.019.100.00	25.020.830.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>463.272.734.00</b>	<b>730.829.150.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>463.272.734.00</b>	<b>730.829.150.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>444.110.327.00</b>	<b>720.057.861.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>311.563.000.00</b>	<b>328.039.828.00</b>
210101	Үндсэн цалин	219.380.700.00	188.907.172.00

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	70.344.200.00	100.436.626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5.216.130.00
210104	Урамшуулал	21.838.100.00	33.479.900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>41.775.000.00</b>	<b>42.022.881.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	29.312.500.00	30.809.318.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.115.600.00	2.802.895.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.492.500.00	1.139.297.00
210204	Ажилгүйдлийн даатгал	623.100.00	783.987.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6.231.300.00	6.487.384.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34.925.083.00</b>	<b>47.908.874.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1.744.802.00	4.527.874.00
210302	Түлш, халаалт	32.986.081.00	42.581.000.00
210303	Цэвэр, бохир ус	194.200.00	800.000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16.871.218.00</b>	<b>21.373.851.00</b>
210401	Бичиг хэрэг	1.002.600.00	1.686.850.00
210402	Тээвэр, шатахуун	10.349.618.00	12.840.100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.569.000.00	3.703.201.00
210404	Ном, хэвлэл	00.00	300.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.000.000.00	1.893.700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950.000.00	950.000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17.832.732.00</b>	<b>39.005.395.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11.720.080.00	31.196.100.00
210502	Хоол, хүнс	6.112.652.00	6.299.295.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1.510.000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8.916.500.00</b>	<b>6.624.630.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	40.000.00
210604	Урсгал засвар	8.916.500.00	6.584.630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1.004.000.00</b>	<b>308.000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1.004.000.00	308.000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3.447.300.00</b>	<b>222.324.183.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3.047.300.00	221.874.183.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400.000.00	450.000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7.775.494.00</b>	<b>12.450.219.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7.775.494.00	12.450.219.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19.162.407.00</b>	<b>10.771.289.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15.602.034.00</b>	<b>00.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15.602.034.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>723.917.00</b>	<b>963.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	723.917.00	00.00
213404	Хөрөнгийн	00.00	963.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2.836.456.00</b>	<b>10.770.326.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2.836.456.00	10.770.326.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>17.179.000.00</u></b>	<b><u>22.310.000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>17.179.000.00</u></b>	<b><u>22.310.000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>17.179.000.00</u></b>	<b><u>22.310.000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b><u>17.179.000.00</u></b>	<b><u>22.310.000.00</u></b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17.179.000.00	22.310.000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-17.179.000.00</u></b>	<b><u>-22.310.000.00</u></b>
<b>7</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>0.00</u></b>

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

8	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<u>000.00</u>	<u>00.00</u>
9	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<u>00.00</u>	<u>00.00</u>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	198.108.353.00	457.646.859.13	626.702.026.08	00.00	1.282.457.238.21
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	198.108.353.00	457.646.859.13	626.702.026.08	00.00	1.282.457.238.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	31.500.000.00	00.00	31.500.000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	198.108.353.00	457.646.859.13	658.202.026.08	00.00	1.313.957.238.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-31.500.000.00	00.00	00.00	-31.500.000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	151.817.895.65	00.00	151.817.895.65
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	198.108.353.00	426.146.859.13	810.019.921.73	00.00	1.434.275.133.86

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	544.327.700.00	519.293.678.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	544.327.700.00	519.293.678.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	544.327.700.00	519.293.678.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	347.099.900.00	328.039.828.00
210101	Үндсэн цалин	196.767.800.00	188.907.172.00
210102	Нэмэгдэл	110.846.200.00	100.436.626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6.006.000.00	5.216.130.00
210104	Урамшуулал	33.479.900.00	33.479.900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46.858.500.00	42.022.881.00
210201	Тэтгэврийн даатгал	32.974.500.00	30.809.318.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.471.000.00	2.802.895.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.776.800.00	1.139.297.00
210204	Ажилгүйдлийн даатгал	694.200.00	783.987.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6.942.000.00	6.487.384.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48.728.300.00	47.908.874.00

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	5.297.300.00	4.527.874.00
210302	Түлш, халаалт	42.631.000.00	42.581.000.00
210303	Цэвэр, бохир ус	800.000.00	800.000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21.506.100.00</b>	<b>21.373.851.00</b>
210401	Бичиг хэрэг	1.700.000.00	1.686.850.00
210402	Тээвэр, шатахуун	12.840.100.00	12.840.100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3.716.000.00	3.703.201.00
210404	Ном, хэвлэл	300.000.00	300.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.000.000.00	1.893.700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950.000.00	950.000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>39.006.100.00</b>	<b>39.005.395.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31.196.100.00	31.196.100.00
210502	Хоол, хүнс	6.300.000.00	6.299.295.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.510.000.00	1.510.000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27.737.200.00</b>	<b>27.734.630.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8.000.000.00	8.000.000.00
210604	Урсгал засвар	19.737.200.00	19.734.630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>457.300.00</b>	<b>308.000.00</b>
210702	Дотоод албан томилолт	457.300.00	308.000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>450.000.00</b>	<b>450.000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450.000.00	450.000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12484300.00</b>	<b>12450219.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12.484.300.00	12.450.219.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>544.327.700.00</b>	<b>519.293.678.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>455.397.100.00</b>	<b>444.626.774.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	455.397.100.00	444.626.774.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>50.465.500.00</b>	<b>49.646.074.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	50.465.500.00	49.646.074.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>38.465.100.00</b>	<b>25.020.830.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38.465.100.00	25.020.830.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>26.00</b>	<b>22.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00

**2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

<b>НТ-2</b>			
<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН</b>			
/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18.649.334.00</b>	<b>223.074.183.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18.649.334.00</b>	<b>223.074.183.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18.649.334.00</b>	<b>223.074.183.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>223.074.183.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		223.074.183.00
<b>213403</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>		<b>963.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>18.649.334.00</b>	<b>223.075.146.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18.649.334.00</b>	<b>223.075.146.00</b>

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15.602.034.00	74.880.646.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3.047.300.00	00.00
131107	Нэмэлт санхүүжилт		148.194.500,00
8	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>000.00</b>	<b>00.00</b>
9	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Ичинхорлоо нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Ч.Сүрэнлхам нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж, хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эмчилгээ оношилгооны орчин үеийн аргыг нэвтрүүлснээр хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/63 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 519,704.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,795.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,846.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 9,149.1 мянган төгрөг буюу 3,302.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн 148,194.5 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 101,740.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланг орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,434,275.1 мянган төгрөг болж өмнөх оноос 147,997.4 мянган төгрөгөөр буюу 10,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	42.469.3	158.552.8	116.083.5

**Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	101.740.0	101.740.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	42.469.3	56.812.8	14.343.5
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1.243.808.4</b>	<b>1.275.722.3</b>	<b>31.913.9</b>
Үндсэн хөрөнгө	1.427.253.4	1.461.015.9	33.762.5
Хуримтлагдсан элэгдэл	(183.445.0)	(185.293.6)	(1.848.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1.286.277.7</b>	<b>1.434.275.1</b>	<b>147.997.4</b>
Өр төлбөр	3.820.4	-	(3.820.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1.282.457.2	1.434.275.1	151.817.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1.286.277.7</b>	<b>1.434.275.1</b>	<b>147.997.4</b>

Эх сурвалж: 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаас

Бараа материалын дансны үлдэгдэл 56,812.8 мянган төгрөг болж 14,343.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын дансны үлдэгдэл 13,476.6 мянган төгрөг болж өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Авлага дансны үлдэгдэл 101,740.0 мянган төгрөг байгаа нь ЭМДС-гаас авах Ковид-19 цар тахлын өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилтийн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,461,015.9 мянган төгрөг болж 33,762.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 9,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, УИХ-ын гишүүны хандиваар 12,203.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Аймгийн Эрүүл мэндийн газраас 14,359.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Аймгийн орон нутгийн өмчийн газраас 2,708.5 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг тус тус үнэ төлбөргүй авсан ба Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.12.28 өдрийн 156 тоот тогтоолоор 52,818.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,434,275.1 мянган төгрөг болж 151,817.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлт нөлөөлжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 544,327.7 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 544,327.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 455,397.1 мянга, орон нутгийн төсвөөс 50,465.5 мянга, ЭМДС-гаас 38,465.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 455,397.1 мянга, орон нутгийн төсвөөс 49,646.1 мянга, ЭМД-аас 25,020.8 мянга, нийт 530,063.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 519,293.6 мянган төгрөгийг зарцуулж, 10,770.3 мянган төгрөгийг буцаан

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 819.4 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 13,444.3 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 530,063.9 мянган төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардал 23,89567 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь батлагдсанаас 2 орон тоо дутуу ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 223,075.1 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 148,194.5 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Тайлант онд сумын хэмжээнд цар тахлын дэгдэлт их байсан ба тархалтыг бууруулах зорилгоор сумын Засаг даргын нөөц хөрөнгө болон эрүүл мэндийн даатгалын газраас хэвтэн эмчлүүлсэн өвчтөний нэхэмжилсэн санхүүжилтээр нөөц бүрдүүлэн ажилласан.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Баян ташаагийн эх аудит” ХХК-ийн аудитор Ч.Чимгээ санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын 38 ажил тусгагдсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 91.6 хувьтай үнэлэгдсэн.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 813,251.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 293,547.2 мянган төгрөгөөр буюу 56,6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,983.8 мянга, хангамж, бараа материалын зардал 61,256.8 мянга, нормативд зардал 50,848.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 152,362.0 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 12,840.1 мянган төгрөгөөр худалдан авах гэрээг НИК ХХК-тай байгуулсан байна. Эмийн худалдан авалтынтын тендерийг аймгийн ЭМГ-аас системийн хэмжээгээр нэгдсэн журмаар зохион байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан, Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарч мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулан ажиллаж байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 110,740.0 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан